



2022 оны 03 дугаар сарын 04  
№09 /1207/

# ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

ᠲᠥᠷᠢᠶᠢᠨ  
ᠮᠡᠳᠡᠭᠡᠯᠡᠯ

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠬᠡ ᠬᠤᠷᠢᠯ ᠠᠯᠪᠠᠨ ᠮᠡᠳᠡᠭᠡᠯᠡᠯ

ᠮᠣᠩᠭᠣᠯ  
ᠤᠯᠤᠰ  
ᠶ᠋ᠢᠬᠡ ᠬᠤᠷᠢᠯ  
ᠠᠯᠪᠠᠨ ᠮᠡᠳᠡᠭᠡᠯᠡᠯ



ГАРЧИГ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

205.	Монгол Улсын Их Хурлын гишүүний ёс зүйн дүрмийг шинэчлэн батлах тухай	Дугаар 105	794
206.	Шинэ сэргэлтийн бодлого батлах тухай	Дугаар 106	819

ТЭГШ

Үндсэн хууль, мөн түүний зөвшөөрлийн хууль

Үндсэн хууль, мөн түүний зөвшөөрлийн хууль, мөн түүний зөвшөөрлийн хууль, мөн түүний зөвшөөрлийн хууль

030

Үндсэн хууль, мөн түүний зөвшөөрлийн хууль, мөн түүний зөвшөөрлийн хууль, мөн түүний зөвшөөрлийн хууль

067



## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2021 оны 12 дугаар  
сарын 30-ны өдөр

Дугаар 105

Улаанбаатар  
хот

### Монгол Улсын Их Хурлын гишүүний ёс зүйн дүрмийг шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэг, 7 дугаар зүйлийн 7.1, 7.2 дахь хэсэг, 8 дугаар зүйлийн 8.1.21 дэх заалт, Төрийн албаны тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.“Монгол Улсын Их Хурлын гишүүний ёс зүйн дүрэм”-ийг хавсралтаар шинэчлэн баталсугай.

2.Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын Их Хурлын Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хороо /Б.Бат-Эрдэнэ/-нд даалгасугай.

3.Энэ тогтоолыг баталсантай холбогдуулан “Монгол Улсын Их Хурлын гишүүний ёс зүйн дүрмийг батлах тухай” Монгол Улсын Их Хурлын 2009 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн 34 дүгээр тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**Г.ЗАНДАНШАТАР**

Монгол Улсын Их Хурлын 2021 оны  
105 дугаар тогтоолын хавсралт

### МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮНИЙ ЁС ЗҮЙН ДҮРЭМ

#### Нэг.Нийтлэг үндэслэл

1.1.Монгол Улсын Их Хурлын гишүүн /цаашид “гишүүн” гэх/ нь бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ “... би ард түмнийхээ элчийн хувьд нийт иргэн, улсын ашиг сонирхлыг эрхэмлэн, төрт ёс, түүх, соёлынхоо уламжлалыг хүндэтгэж, Монгол Улсын Үндсэн хуулийг дээдлэн сахиж, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байж, гишүүний үүргээ чин шударгаар биелүүлэхээ тангараглая. Миний бие энэ тангаргаасаа няцвал хуулийн хариуцлага хүлээнэ.” хэмээн өргөсөн тангаргаа сахин биелүүлэхэд нь туслахад энэхүү Ёс зүйн дүрмийн зорилго оршино.

1.2.Гишүүн үйл ажиллагаандаа энэхүү дүрмээр тогтоосон ёс зүйн хэм хэмжээг баримтлахын зэрэгцээ Монгол Улсын Үндсэн хууль<sup>1</sup>, Монгол Улсын Их Хурлын тухай хууль<sup>2</sup>, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хууль<sup>3</sup>, Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль<sup>4</sup>, Төрийн албаны тухай хууль<sup>5</sup>, Авлигын эсрэг хууль<sup>6</sup>, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль<sup>7</sup> болон холбогдох бусад хууль тогтоомжид заасан хэм хэмжээг дагаж мөрдөнө.

### **Хоёр.Гишүүний ёс зүйн хэм хэмжээ**

2.1.Гишүүн ард түмнийхээ элчийн хувьд бүрэн эрхийнхээ хугацаанд дараах ёс зүйн хэм хэмжээг сахин мөрдөнө:

- 2.1.1.нийт иргэн, улсын ашиг сонирхлыг эрхэмлэх;
- 2.1.2.төрт ёс, түүх, соёлынхоо уламжлалыг хүндэтгэх;
- 2.1.3.Үндсэн хууль, хууль ёсыг дээдлэн сахиж биелүүлэх;
- 2.1.4.авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх;
- 2.1.5.биеэ авч явах, шударга байдлаараа үлгэр дуурайл

үзүүлэх.

2.2.Гишүүн энэ дүрмийн 2.1-д заасан ёс зүйн хэм хэмжээг сахин мөрдөхөөс гадна дараах ёс зүйн шаардлагыг биелүүлэх үүрэгтэй:

2.2.1.гишүүний бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ баримтлах ёс зүйн шаардлага;

2.2.2.ашиг сонирхлын зөрчилтэй холбоотой ёс зүйн шаардлага;

2.2.3.төсөв зарцуулалт, санхүүтэй холбоотой ёс зүйн шаардлага;

2.2.4.хөрөнгө, орлогын мэдүүлэгтэй холбоотой ёс зүйн шаардлага;

<sup>1</sup>Монгол Улсын Үндсэн хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 1992 оны 01 дугаарт нийтлэгдсэн.

<sup>2</sup>Монгол Улсын Их Хурлын тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2020 оны 22 дугаарт нийтлэгдсэн.

<sup>3</sup>Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2020 оны 22 дугаарт нийтлэгдсэн.

<sup>4</sup>Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2019 оны 49 дугаарт нийтлэгдсэн.

<sup>5</sup>Төрийн албаны тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2018 оны 01 дугаарт нийтлэгдсэн.

<sup>6</sup>Авлигын эсрэг хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2006 оны 35 дугаарт нийтлэгдсэн.

<sup>7</sup>Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2012 оны 08 дугаарт нийтлэгдсэн.

2.2.5. албан томилолттой холбоотой ёс зүйн шаардлага;

2.2.6. шагнал, бэлэг дурсгал хүлээн авахтай холбоотой ёс зүйн шаардлага;

2.2.7. Улсын Их Хурлын сонгуулийн сурталчилгааны үеэр баримтлах ёс зүйн шаардлага.

### **Гурав. Гишүүн бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ баримтлах ёс зүйн шаардлага**

3.1. Гишүүн ард түмний элчийн хувьд нийт иргэн, улсын эрх ашгийг эрхэмлэн, төрт ёс, түүх соёлынхоо уламжлалаа дээдлэн ажиллана.

3.2. Бусдын нэр төр, алдар хүнд, эрх, хууль ёсны ашиг сонирхлыг эрхэмлэн, хүндэтгэлтэй хандах, бусдыг гэмт хэрэгт холбогдуулан гүтгэх, доромжлохыг цээрлэнэ.

3.3. Гишүүн өвчтэй, чөлөөтэй, албан томилолтоор ажиллахаас бусад тохиолдолд чуулганы нэгдсэн, Байнгын, дэд, түр хорооны хуралдаанд товлосон хугацаанд ирж оролцох үүрэгтэй.

3.4. Гишүүн өвчтэй буюу өвчтэй хүн асарсан бол эмнэлгийн магадалгаа, гадаад, дотоод албан томилолтоор явсан тохиолдолд томилолтын хуудсыг гишүүний ажлын алба Улсын Их Хурлын Тамгын газарт хүргүүлнэ.

3.5. Чуулганы нэгдсэн, Байнгын, дэд, түр хорооны хуралдааны дэг зөрчиж хуралдааны хэвийн үйл ажиллагааг алдагдуулах, хуралдаанд үг хэлэх, байр сууриа илэрхийлэхдээ бүдүүлэг үг хэллэг хэрэглэх, бусдын нэр төр, алдар хүндийг гутаах, доромжлохыг хориглоно.

3.6. Гишүүн цөөнхийн саналыг хүндэтгэн асуудлыг олон ургалч үзлийн үүднээс чөлөөтэй хэлэлцэж, олонхын саналаар шийдвэрлэх зарчмыг баримтална.

3.7. Олон улсын хөл хориот өвчин гарсан онцгой нөхцөл болон хууль тогтоомжид заасан хөл хорио, бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн тохиолдолд Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд заасан хялбаршуулсан болон цахим хуралдааны дэгийг мөрдөнө.

3.8. Гишүүн үзэл бодол, байр сууриа илэрхийлэхдээ албан ёсны эх сурвалжийг баримтлах ба олон нийтийг төөрөгдүүлэх, үндэслэлгүй мэдээлэл хийхийг хориглоно.

3.9.Гишүүн бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ хувийн ашиг сонирхлоор хэн нэг хүн, хэсэг бүлэг хүмүүс, байгууллага, аж ахуйн нэгжийн үйл ажиллагааг дэмжихийг хориглоно.

3.10.Гишүүн бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ өөрийн хамаарал бүхий этгээдэд давуу байдал бий болгох зорилгоор хяналт шалгалт хийх, хариуцлага хүлээлгэх, гэрээ байгуулах, хууль санаачлах, боловсруулах, санал хураалтад оролцохыг хориглоно.

3.11.Гишүүн бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ нууцын тухай хууль тогтоомжийг баримталж, төр, байгууллага, хувь хүний хуулиар хамгаалсан нууцыг чанд хадгална.

3.12.Гишүүний харилцуур утас болон бусад тусгай хэрэглээний холбооны хэрэгсэл төрийн хамгаалалтад байх бөгөөд бүрэн эрхээ хэрэгжүүлэх, үйл ажиллагаагаа явуулахтай холбогдсон бусад гишүүн, аливаа этгээдийн шуудан, захидал харилцааны болон мэдээллийн нууцыг задруулахыг хориглоно.

3.13.Засгийн газрын гишүүнээр давхар ажиллаж байгаа гишүүн нь Улсын Их Хурлаас байгуулагдах хяналт шалгалтын ажлын хэсгийн бүрэлдэхүүнд орох, түүнчлэн хяналт шалгалтын ажлын хэсэг байгуулахаар санаачлах, санал оруулахыг хориглоно.

3.14.Гишүүн бүрэн эрхийн хүрээнд хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төсөл санаачилж Улсын Их Хуралд өргөн мэдүүлсний дараа тухайн хууль тогтоомжийн төслийг Улсын Их Хурлын чуулганы хуралдааны хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсэгт орж ажиллахыг хориглоно.

3.15.Байнгын, дэд, түр хорооны эрхлэх асуудлын хүрээнд хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн хэрэгжилтийг шалгаж санал, дүгнэлт гаргах, шийдвэрийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэгт орж ажилласны дараа холбогдох төрийн болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгжид хяналт шалгалт явуулах эрх бүхий байгууллагад нөлөөлөхийг хориглоно.

3.16.Гишүүн төрийн албан хаагчаар албаны чиг үүрэгт нь үл хамаарах ажил, үүрэг гүйцэтгүүлэхээр заавар, чиглэл өгөх, нийтээр хүлээн зөвшөөрсөн зан суртахууны хэм хэмжээнд харш үйлдэл, эс үйлдэхүй хийхийг шаардахыг хориглоно.

3.17.Төрийн ёслол, хүндэтгэлийн болон Төрийн ордны дэг журмыг чанд баримтлахаас гадна Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн, Байнгын, дэд, түр хорооны хуралдааны танхимд биеэ зөв авч явах үүрэгтэй ба бусдыг ялгаварлан гадуурхах, зохисгүй үйлдэл гаргахыг хориглоно.



### **Дөрөв.Ашиг сонирхлын зөрчилтэй холбоотой ёс зүйн шаардлага**

4.1.Гишүүн ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлж, улс төрийн үйл ажиллагааг нийтийн ашиг сонирхолд нийцүүлэх нөхцөлийг баримталж ажиллана.

4.2.Гишүүн төрийн өмчлөлийн эд хөрөнгө, техник, тээврийн хэрэгсэл, санхүүгийн нөөц болон мэдээллийг зөвхөн албан ажлын хэрэгцээнд ашиглана.

4.3.Гишүүн бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ аливаа асуудлаар гадаадын байгууллага, албан тушаалтанд амлалт өгөхгүй байх, мөн гадаад улсын аж ахуйн нэгж, байгууллагын нөлөөнд орж улсын ашиг сонирхолд харшлах үйлдэл хийхийг хориглоно.

4.4.Гишүүний нэр хүнд, бүрэн эрхийг гэр бүлийн болон нэгдмэл сонирхолтой этгээдийн санхүүгийн байдлыг дээшлүүлэхэд ашиглахыг хориглоно.

4.5.Гишүүн бүрэн эрхийн хугацаанд эцэг, эх, төрсөн ах, эгч, дүү, гэр бүлийн гишүүн, хамтран амьдрагч, эхнэр /нөхөр/-ийн эцэг, эх, төрсөн ах, эгч, дүүг төрийн байгууллагын ажил, албан тушаалд томилуулах санал болгохыг хориглоно.

4.6.Гишүүн бүрэн эрхийн хугацаанд хуульд зааснаас бусад тохиолдолд иргэн, хуулийн этгээдээс хандив, мөнгөн хөрөнгө, шан харамж гаргахыг зуучлах, санал болгохыг хориглоно.

4.7.Гишүүний бүрэн эрхэд харшилсан санхүү, худалдааны болон бусад ижил төстэй хэлэлцээрт оролцохыг хориглоно.

4.8.Ажил үүргийн дагуу олж авсан мэдээ, мэдээллийг хувийн хэрэгцээнд ашиглахгүй байх, бусдад ашиглуулахыг хориглоно.

4.9.Гишүүн бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ бусдын ашиг сонирхлын нөлөөнд автах, эдийн засгийн хараат байдалд орохыг хориглоно.

4.10.Гишүүн бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ өөрийн нэр хүнд, эрх мэдлийг ашиглан үнэт цаас, эд хөрөнгө олж авах, давуу эрх эдлэх, бусдад давуу байдал олгох үйл ажиллагаа явуулах, аливаа этгээдэд нөлөөлөхийг хориглоно.

4.11.Гишүүн хууль тогтоомжоор хориглосон аливаа ажил, албан тушаал эрхлэх, түүнчлэн цалин хөлс, урамшуулал авах, өгөхийг шаардахыг хориглоно.

4.12.Хэлэлцэж байгаа асуудал нь ашиг сонирхлын зөрчил үүсэхээр бол гишүүн энэ тухай хуралдаан даргалагчид урьдчилан мэдэгдэж, санал хураалтад оролцохоос сайн дураараа татгалзана.

4.13.Гишүүн бүрэн эрхийнхээ хугацаанд хуулиар зөвшөөрснөөс бусад ажил, албан тушаал давхар эрхлэхийг хориглоно.

#### **Тав.Төсөв зарцуулалт, санхүүтэй холбоотой ёс зүйн шаардлага**

5.1.Гишүүн Улсын Их Хурлаас баталсан журмын дагуу тухайн жилийн батлагдсан төсвийн хүрээнд үйл ажиллагаагаа төлөвлөн төсвөө үр ашигтай удирдах үүрэг хүлээнэ.

5.2.Гишүүн өөрт хуваарилагдсан төсвийг зориулалтын бусаар зарцуулахыг хориглоно.

#### **Зургаа.Хөрөнгө орлогын мэдүүлэгтэй холбоотой ёс зүйн шаардлага**

6.1.Гишүүн хөрөнгө, орлогын мэдүүлгийг хууль тогтоомжид заасан хугацаанд бүрэн, үнэн зөв гаргаж, мэдүүлнэ. Энэ асуудалд Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хороо /цаашид “Байнгын хороо” гэх/ хяналт тавина.

6.2.Гишүүн бүрэн эрхийнхээ хугацаанд хуулиар зөвшөөрсөн албан тушаал хавсран гүйцэтгэснээс олох орлогын хэмжээ нь гишүүний жилийн үндсэн цалингийн 40 хувиас хэтрэхгүй байвал зохино.

6.3.Гишүүн иргэдийн боловсролыг дээшлүүлэх, оюуны хөгжилд хувь нэмэр оруулах зорилгоор яриа хийх, илтгэл тавих, өгүүлэл, ном бичсэнийхээ төлөө урамшуулал авч болох бөгөөд энэхүү орлогоо хөрөнгө, орлогын мэдүүлэгт заавал тусгана.

#### **Долоо.Албан томилолттой холбоотой ёс зүйн шаардлага**

7.1.Улсын Их Хурлын даргын зөвшөөрөлгүйгээр Засгийн газар, түүний харьяа байгууллага, түүнчлэн гадаад, дотоодын аж ахуйн нэгж, байгууллага, иргэний зардлаар гадаадад зорчихыг хориглоно.





7.2.Гишүүн албан томилолтоор гадаадад ажиллахдаа батлагдсан удирдамж, чиглэлийг чанд баримтална.

7.3.Гишүүн гадаад улсад албан томилолтоор ажиллах хугацаандаа Монгол Улсын нэр хүндэд харш аливаа үйлдэл гаргахгүй байж, дипломат ёсыг чанд баримтлах үүрэгтэй.

7.4.Гишүүн ард түмнийхээ элчийн хувьд гадаад, дотоодод хувийн журмаар зорчих, албан томилолтоор ажиллахдаа эх орон, Улсын Их Хурлын нэр хүндийг эрхэмлэн дээдлэнэ.

#### **Найм.Шагнал, бэлэг дурсгал хүлээн авахтай холбоотой ёс зүйн шаардлага**

8.1.Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын даргын зөвшөөрөлгүйгээр гадаад орны төрийн дээд цол, одон медаль, төрийн бусад шагнал авахыг хориглоно.

8.2.Гишүүн бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ ашиг сонирхол нь хөндөгдөх дотоод, гадаадын иргэн, хуулийн этгээдэд хууль бус давуу байдал олгох, үгсэн тохирох, амлалт өгөх, бэлэг, шан харамж, хөнгөлөлттэй үйлчилгээ, зээл авах, эсхүл эдгээрийг хүсэх, шаардах замаар эдийн болон эдийн бус эрх олж авахыг хориглоно.

8.3.Гишүүн эрх мэдлийнхээ хүрээнд хянан шалгаж байгаа байгууллага, албан тушаалтнаас бэлэн мөнгө болон мөнгөөр үнэлэгдэх үнэт зүйлс, үнэ төлбөргүйгээр үйлчилгээ авахыг хориглоно.

#### **Ес.Сонгуулийн сурталчилгааны үеэр баримтлах ёс зүйн шаардлага**

9.1.Гишүүн Улсын Их Хурлын гишүүнд сонгогдохоосоо өмнө оффшор бүсэд өөрийн нэр дээр банкны данс нээлгэсэн, мөнгөн хөрөнгө байршуулсан, гадаад улсад хөдлөх, үл хөдлөх хөрөнгө өмчилсөн, хувь нийлүүлэх замаар хуулийн этгээд үүсгэн байгуулсан бол холбогдох байгууллагад урьдчилан мэдүүлнэ. Энэ нь нэр дэвшигчийн хамаарал бүхий этгээдэд нэгэн адил хамаарна.

9.2.Гишүүн Улсын Их Хурлын гишүүнээр сонгогдохоосоо өмнө Улсын Их Хурлын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1-д зааснаас бусад ажил, албан тушаал эрхэлж байсан бол гишүүний тангараг өргөхөөсөө өмнө тухайн ажил, албан тушаалаасаа чөлөөлөгдөх шийдвэр гаргуулсан байна.

9.3.Гишүүн холбогдох хуульд заасан журмын дагуу сонгуульд нэр дэвших тохиолдолд бүрэн эрхээ хэрэгжүүлэхтэй нь холбогдуулан олгосон ажлын байр, санхүүгийн эх үүсвэр, холбоо, мэдээлэл, баримт бичиг, тээврийн хэрэгсэл, төрийн өмчийн бусад эд зүйлийг сонгуулийн сурталчилгааны ажилд ашиглахыг хориглоно.

### **Арав.Улсын Их Хурлын гишүүний ёс зүйн зөрчлийг шалган шийдвэрлэх**

10.1.Байнгын хороо гишүүний ёс зүйн зөрчилтэй холбоотой дараах гомдол, мэдээлэл, хүсэлтийг хүлээн авна:

10.1.1.Улсын Их Хурлын даргын нэр дээр иргэд, хуулийн этгээдээс гишүүний ёс зүйн зөрчилтэй холбоотой бичгээр ирүүлсэн гомдол, мэдээлэл;

10.1.2.Байнгын хороонд иргэн, хуулийн этгээдээс бичгээр ирүүлсэн гомдол, мэдээлэл;

10.1.3.авлига, ашиг сонирхлын зөрчилтэй гэж ойлгогдохуйц нөхцөл байдал үүсвэл гишүүн Байнгын хороонд шалгуулахаар бичгээр хандсан хүсэлт;

10.1.4.Улсын Их Хурлын Тамгын газраас гаргасан мэдээ, тайлан.

10.2.Байнгын хороо гишүүний ёс зүйн зөрчилтэй холбоотой гомдол, мэдээллийг Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль<sup>8</sup>, Улсын Их Хурлын гишүүний ёс зүйн дүрмийн дагуу хянан шийдвэрлэнэ.

10.3.Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хороо дараах өргөдөл, гомдол, мэдээллийг хянан үзэхгүй:

10.3.1.нэр, хаяг, гарын үсэггүй өргөдөл, гомдол, мэдээллийг Улсын Их Хурлын дарга, Байнгын хорооноос хянан үзэхгүйгээр буцаана;

10.3.2.гишүүн тангараг өргөж, бүрэн эрх нь хэрэгжиж эхэлснээс өмнөх хугацаанд гарсан ёс зүйн зөрчлийн асуудлаар хандсан гомдол, мэдээлэл;

<sup>8</sup>Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 1995 оны 07 дугаарт нийтлэгдсэн.

10.3.3. гишүүний нэр хүндийг олон нийтийн мэдээллийн хэрэгслээр гутаан доромжилсон асуудлаар эрх нь зөрчигдсөн этгээдээс бусад этгээдийн ирүүлсэн гомдол, мэдээлэл;

10.3.4. гишүүний ёс зүйн зөрчилтэй холбоотой тухайн асуудлаар өмнө нь хандаж, албан ёсны хариу авсан бол;

10.3.5. гишүүн ёс зүйн зөрчил гаргасан гэж үзэж хэвлэлийн хурал хийж, ард түмнээсээ албан ёсоор уучлалт гуйсан бол;

10.3.6. гишүүний ёс зүйн зөрчлийн асуудал нь хууль, хяналтын байгууллагад шалгагдаж байгаа тохиолдолд.

10.4. Гишүүний ёс зүйн зөрчилтэй холбоотой гомдол, мэдээллийг Байнгын хорооны дарга хүлээн авч Байнгын хорооны аль нэг гишүүнд хянуулахаар шилжүүлнэ:

10.4.1. гишүүн гомдол, мэдээлэлд холбогдсон гишүүнтэй уулзаж, тайлбар, саналыг сонсож тэмдэглэл хөтлөх;

10.4.2. гишүүн шаардлагатай гэж үзвэл холбогдох байгууллагаас баримт бичиг, тайлбар, бусад лавлагаа материалыг гаргуулж авах;

10.4.3. гишүүн шаардлагатай гэж үзвэл Улсын Их Хурлын Тамгын газраас холбогдох мэдээ, мэдээллийг гаргуулж авах.

10.5. Шалгалтын явцад гишүүний ёс зүйн зөрчлийн шинж байдал нь ёс зүйн хариуцлага тооцохооргүй бол шалгалтын дүнг үндэслэн Байнгын хорооны дарга тухайн гишүүнийг дуудаж уулзан зөвлөгөө өгнө.

10.6. Шалгалтын явцад гомдол, мэдээлэлд дурдсан гишүүний ёс зүйн зөрчлийн асуудлыг Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцүүлэх шаардлагатай гэж үзвэл шалгалтын дүнг Байнгын хорооны даргад танилцуулна.

10.7. Дараах тохиолдолд Улсын Их Хурлын гишүүний ёс зүйн зөрчлийн асуудлыг Байнгын хорооны хуралд оруулах ба Байнгын хорооны хурлыг Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд заасан журмын дагуу явуулна:

10.7.1. Улсын Их Хурлын тухай хуулийн 8.1.25-д заасан хөрөнгө, орлогын мэдүүлгийг бүрэн эрхийн хугацаанд зохих журмын дагуу 2 ба түүнээс дээш удаа үнэн зөв гаргаж өгөөгүй бол;

10.7.2.Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 18.1-д заасан хариуцлагыг хуралдаан даргалагчаас тухайн жилд 3 ба түүнээс дээш удаа ногдуулсан бол;

10.7.3.хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр чуулганы нэгдсэн, Байнгын, дэд, түр хорооны хуралдааныг тухайн жилд хуралдааны /цахим/ ирцэд бүртгүүлсэн дүнгээр хоцорсон буюу тасалсан цаг нь ажлын 5 өдрийн цагаас дээш гарсан бол.

10.8.Энэ дүрмийн 10.7.1-д заасан хөрөнгө орлогын мэдүүлэг Авлигатай тэмцэх газраас ирүүлсэн мэдээллээр, 10.7.2-д заасан хариуцлага нь тухайн өдрийн нэгдсэн, Байнгын, дэд, түр хорооны хуралдааны тэмдэглэлээр, 10.7.3-д заасан ирцийн бүртгэл нь Улсын Их Хурлын Тамгын газраас гаргасан албан ёсны баримтаар баталгаажна.

10.9.Гишүүнд Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 18.1-д заасан хариуцлага хүлээлгэсэн тухай хуралдааны тэмдэглэл, гишүүдийн хуралдааны ирцийн мэдээллийг Хуралдаан зохион байгуулах хэлтсээс сар бүр Байнгын хороонд ирүүлнэ.

10.10.Гишүүний чуулганы нэгдсэн, Байнгын, дэд, түр хорооны хуралдааны ирцэд бүртгүүлэн, хуралдаанаар асуудал хэлэлцэх, санал хураалтад оролцсон идэвхийн талаар Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хорооны дарга чуулганы нэгдсэн, Байнгын, дэд, түр хорооны хуралдаанд оролцохдоо танилцуулж болно.

### **Арван нэг.Ёс зүйн шаардлагыг зөрчсөн тохиолдолд хүлээлгэх хариуцлага**

11.1.Байнгын хороо гишүүний ёс зүйн зөрчил гаргасан тухай гомдол, мэдээллийг Монгол Улсын Их Хурлын тухай, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд заасан журмын дагуу хэлэлцэж ёс зүйн зөрчлийн шинж байдлыг харгалзан дараах сахилгын хариуцлага ногдуулна:

11.1.1.сануулга өгөх;

11.1.2.уучлал гуйхыг үүрэг болгох;

11.1.3.албан тушаалын цалингийн хэмжээг 6 сар хүртэл хугацаагаар 20 хүртэл хувиар бууруулах.

11.2.Энэ дүрмийн 11.1-д заасан хариуцлагыг Байнгын хорооны тогтоолоор ногдуулна.



11.3.Гишүүн энэ дүрмийн 11.1.2-т заасан хариуцлага хүлээх шийдвэр гарсан өдрөөс хойш ажлын 5 өдрийн дотор сайн дураараа биелүүлж, энэ тухайгаа Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хороонд бичгээр мэдэгдэх үүрэгтэй. Хэрэв энэ үүргээ биелүүлээгүй бол Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хорооны дарга, гишүүн тухайн гишүүнд ногдуулсан ёс зүйн хариуцлагыг биелүүлээгүй талаар олон нийтэд албан ёсоор мэдээлнэ.

11.4.Гишүүнд энэ дүрмийн 11.1.3-т заасан хариуцлага ногдуулсан тухай Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хорооны тогтоолыг Улсын Их Хурлын даргад хүргүүлнэ.

11.5.Гишүүний ёс зүйн зөрчлийн хэм хэмжээ нь гэмт хэргийн болон авлигын шинжтэй бол Байнгын хорооны гишүүдийн олонхын саналаар харьяаллын дагуу холбогдох байгууллагад албан бичгээр шилжүүлнэ.

11.6.Энэ дүрмийн 11.1-д заасан хариуцлагыг гишүүнд ногдуулсан талаар Улсын Их Хурлын албан ёсны цахим хуудаст Улсын Их Хурлын Тамгын газрын Хэвлэл, мэдээлэл, олон нийттэй харилцах хэлтэс ажлын 5 өдрийн дотор нийтэлнэ.

11.7.Гишүүний үйлдсэн ёс зүйн зөрчилд энэ бүлэгт заасан хариуцлагын төрлийг давхардуулан ногдуулахгүй.

11.8.Ёс зүйн зөрчлийг илрүүлснээс хойш 6 сар, зөрчил гаргаснаас хойш 1 жилийн хугацаа өнгөрсөн бол гишүүнд 11.1-д заасан хариуцлага ногдуулж болохгүй.

11.9.Байнгын хорооны хуралдаанаар гишүүнд ёс зүйн хариуцлага хүлээлгэсэн эсэх, хэрхэн шийдвэрлэсэн талаар гомдол, мэдээлэл гаргасан иргэн, байгууллагад албан бичгээр хариу өгнө.

### **Арван хоёр.Бусад**

12.1.Энэ дүрмийн хэрэгжилтийг Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хороо хариуцаж, хяналт тавьж ажиллана.

12.2.Байнгын хороо нь эрхлэх асуудлынхаа хүрээний тодорхой асуудлаар нарийвчилсан журмыг батлан мөрдүүлж болно.

--- оОо ---



















Мэгдэжээтэй . . . мэдээлэл мэдээлжээтэй мэдээлжээтэй мэдээлжээтэй мэдээлжээтэй

7. 6. мэдээлэл мэдээлжээтэй мэдээлжээтэй мэдээлжээтэй мэдээлжээтэй мэдээлжээтэй . . . мэдээлжээтэй мэдээлжээтэй мэдээлжээтэй мэдээлжээтэй мэдээлжээтэй

8. 7. мэдээлэл мэдээлжээтэй мэдээлжээтэй мэдээлжээтэй мэдээлжээтэй мэдээлжээтэй

9. 8. мэдээлэл мэдээлжээтэй мэдээлжээтэй мэдээлжээтэй мэдээлжээтэй мэдээлжээтэй . . . мэдээлжээтэй мэдээлжээтэй мэдээлжээтэй мэдээлжээтэй мэдээлжээтэй

10. 9. мэдээлэл мэдээлжээтэй мэдээлжээтэй мэдээлжээтэй мэдээлжээтэй мэдээлжээтэй

11. 10. мэдээлэл мэдээлжээтэй мэдээлжээтэй мэдээлжээтэй мэдээлжээтэй мэдээлжээтэй

12. 11. мэдээлэл мэдээлжээтэй мэдээлжээтэй мэдээлжээтэй мэдээлжээтэй мэдээлжээтэй

13. 12. мэдээлэл мэдээлжээтэй мэдээлжээтэй мэдээлжээтэй мэдээлжээтэй мэдээлжээтэй

14. 13. мэдээлэл мэдээлжээтэй мэдээлжээтэй мэдээлжээтэй мэдээлжээтэй мэдээлжээтэй . . . мэдээлжээтэй мэдээлжээтэй мэдээлжээтэй мэдээлжээтэй мэдээлжээтэй

15. 14. мэдээлэл мэдээлжээтэй мэдээлжээтэй мэдээлжээтэй мэдээлжээтэй мэдээлжээтэй

16. 15. мэдээлэл мэдээлжээтэй мэдээлжээтэй мэдээлжээтэй мэдээлжээтэй мэдээлжээтэй . . . мэдээлжээтэй мэдээлжээтэй мэдээлжээтэй мэдээлжээтэй мэдээлжээтэй















## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2021 оны 12 дугаар  
сарын 30-ны өдөр

Дугаар 106

Улаанбаатар  
хот

### Шинэ сэргэлтийн бодлого батлах тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Коронавируст халдвар /КОВИД-19/-т цар тахлын эдийн засагт үзүүлж байгаа сөрөг нөлөөллийг бууруулж, эдийн засгийн суурийг тэлэх, “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогыг үр дүнтэй хэрэгжүүлэх, төрийн бүтээмжийг сайжруулах зорилгоор “Шинэ сэргэлтийн бодлого”-ыг 1 дүгээр хавсралтаар, “Шинэ сэргэлтийн бодлого”-ыг хэрэгжүүлэх эхний үе шатны үйл ажиллагааны хөтөлбөрийг 2 дугаар хавсралтаар, “Шинэ сэргэлтийн бодлого”-ын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх Хөгжлийн төслийн жагсаалтыг 3 дугаар хавсралтаар, “Шинэ сэргэлтийн бодлого”-ын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд Монгол Улсын Их Хурлын чуулганаар нэн яаралтай хэлэлцүүлэх хуулийн төслийн жагсаалтыг 4 дүгээр хавсралтаар, Монгол Улсын Их Хуралд 2022 онд үе шаттайгаар өргөн мэдүүлж, хэлэлцүүлэх хуулийн төслийн жагсаалтыг 5 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.“Шинэ сэргэлтийн бодлого”-д тусгагдсан төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгө, санхүүжилтийг улс болон орон нутгийн төсөв, бусад санхүүжилтийн эх үүсвэртэй уялдуулан төр-хувийн хэвшлийн түншлэл, хөрөнгө оруулагчдын идэвхтэй оролцоонд тулгуурлан зохион байгуулахыг Монгол Улсын Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/, Монголбанк /Б.Лхагвасүрэн/-д тус тус даалгасугай.

3.“Шинэ сэргэлтийн бодлого”-д тусгагдсан төсөл, арга хэмжээний хэрэгжилтийг эрчимжүүлэх зорилгоор холбогдох хууль тогтоомжийн төслийг боловсруулж, Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/-т даалгасугай.

4.“Шинэ сэргэлтийн бодлого”-ын зорилго, зорилтын хүрээнд төр, төр-хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжүүлэх Хөгжлийн төслийн жагсаалтад тусгагдаагүй бусад төслийг дэмжиж ажиллахыг Монгол Улсын Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/-т даалгасугай.

5.Энэ тогтоолыг 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**Г.ЗАНДАНШАТАР**

Монгол Улсын Их Хурлын 2021 оны  
106 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт

## ШИНЭ СЭРГЭЛТИЙН БОДЛОГО

“Шинэ сэргэлтийн бодлого” нь Монгол Улсын эдийн засгийн хараат бус, бие даасан байдлыг бэхжүүлэх, Коронавируст халдвар /КОВИД-19/-т цар тахлын эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, хөгжлийг хязгаарлагч хүчин зүйлийг цаг алдалгүй шийдвэрлэж, “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогыг үр дүнтэй хэрэгжүүлэх суурь нөхцөлийг бүрдүүлэх, эдийн засаг, дэд бүтэц болон төрийн бүтээмжийг сайжруулахад чиглэсэн 10 хүртэлх жилийн хугацаанд хэрэгжих дунд хугацааны зорилтот хөтөлбөр юм.

“Шинэ сэргэлтийн бодлого”-ыг хэрэгжүүлснээр урт хугацаанд эдийн засгийн өсөлт дунджаар 6 хувьд хадгалагдаж, нэг хүнд ногдох үндэсний орлого 2 дахин нэмэгдэж, ажиллах хүчний оролцооны түвшин 65 хувьд хүрнэ. Боомтын хүчин чадлыг 3 дахин нэмэгдүүлж, эрчим хүчний эх үүсвэрийг 2 дахин өсгөнө. “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогод дэвшүүлсэн эхний үе шатны зорилго, зорилт хангагдах суурь нөхцөл бүрдэнэ.

“Шинэ сэргэлтийн бодлого”-ын хүрээнд төр-хувийн хэвшил, хөрөнгө оруулагчдын идэвхтэй түншлэлд тулгуурлан Монгол Улсын хөгжлийг хязгаарлаж буй зургаан багц асуудлыг шийдвэрлэх болно.

### Нэг.Боомтын сэргэлт

1.1.Боомтуудын хатуу, зөөлөн дэд бүтцийг хөгжүүлэн ачаа болон зорчигч нэвтрүүлэх хүчин чадлыг дээшлүүлж, экспортыг нэмэгдүүлнэ.

1.2.Хилийн боомтуудыг төмөр зам болон хатуу хучилттай авто замаар үе шаттайгаар бүрэн холбон, тээвэр, логистикийн өрсөлдөх чадварыг дээшлүүлэн ачаа тээврийн урсгалыг сайжруулж, цаашид транзит улс болох суурь нөхцөлийг бүрдүүлнэ.

1.3.Монгол Улсын агаарын зайн зохион байгуулалт, агаарын замын ашиглалтыг сайжруулан дамжин өнгөрөх агаарын хөлгийн тоог нэмэгдүүлж, агаарын тээврийн либералчлалыг үе шаттайгаар үргэлжлүүлэх замаар ачаа тээврийн зангилаа төвийг бий болгож, мөн аялал жуулчлалын салбарыг дэмжинэ.

1.4.Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалд тулгуурлан эдийн засгийн чөлөөт бүс, хуурай боомтуудыг үе шаттайгаар байгуулах замаар худалдааны эргэлтийг нэмэгдүүлнэ.

### **Хоёр.Эрчим хүчний сэргэлт**

2.1.Эрчим хүчний эх үүсвэр, дамжуулах, түгээх шугам сүлжээг шинээр барьж байгуулан хүчин чадлыг өргөтгөн нэмэгдүүлж, эрчим хүчний үйлдвэрлэл, хангамжийн найдвартай байдлыг дээшлүүлнэ.

2.2.Сэргээгдэх эрчим хүчийг зохистой харьцаагаар хөгжүүлэн усан болон хуримтлуурын станц барьж, эрчим хүчний нэгдсэн системийн найдвартай, тогтвортой байдлыг хангана.

2.3.Эрчим хүчний салбарыг санхүү, эдийн засгийн бие даасан тогтолцоонд үе шаттайгаар шилжүүлнэ.

2.4.Зүүн хойд Азийн эрчим хүчний нэгдсэн сүлжээнд эрчим хүч нийлүүлэх сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэр, сүлжээнд холбогдох хэт өндөр хүчдэлийн цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станцын бэлтгэл ажлыг хангана.

2.5.Оросын Холбооны Улсаас Бүгд Найрамдах Хятад Ард Улс руу Монгол Улсын газар нутгаар дамжин өнгөрөх байгалийн хий дамжуулах хоолойг барих бүтээн байгуулалтын ажлыг эрчимжүүлнэ.

### **Гурав.Аж үйлдвэржилтийн сэргэлт**

3.1.Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл олголтыг бүрэн цахимжуулж, өртөг зардлыг бууруулан хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлж, дэвшилтэт техник, технологид суурилсан, нэмүү өртөг шингэсэн уул уурхайн бүтээгдэхүүний хэмжээг дээшлүүлэн эрдэс баялгийн баталгаат нөөцийг арвижуулна.

3.2.Нэмүү өртөг шингэсэн хүнд үйлдвэрлэлийг хөгжүүлж, дотоодын бүтээн байгуулалтын хэрэгцээг хангаж, экспортыг нэмэгдүүлнэ.

3.3.Газрын тосны баталгаат нөөцийг өсгөж, олборлолтыг нэмэгдүүлэх замаар дотоодын газрын тос боловсруулах үйлдвэрийг түүхий эдээр хангана.

3.4.Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг дэвшилтэт техник, технологи, инновацад тулгуурлан хөгжүүлж, шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээ болон үйлдвэрлэлийн хэмжээг нэмэгдүүлнэ.

3.5.Хөдөө аж ахуйн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний нөөцтэй уялдуулан боловсруулах үйлдвэрийн хүчин чадлыг нэмэгдүүлэх замаар хагас боловсруулсан бүтээгдэхүүний экспортын хувь хэмжээг бууруулан нэмүү өртөг шингэсэн эцсийн бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлнэ.

3.6.Шинжлэх ухаанд суурилсан өндөр технологи, блокчейн, хиймэл оюун ухааны ололтыг нэвтрүүлж, дижитал эдийн засгийн чиг хандлагад нийцсэн аж үйлдвэржилтийг хөгжүүлнэ.

### **Дөрөв.Хот, хөдөөгийн сэргэлт**

4.1.Нийслэл Улаанбаатар хотын нийтийн тээврийн чанар, стандартыг сайжруулан багтаамж ихтэй шинэ төрлийн нийтийн тээврийн хэрэгслийг үйлчилгээнд нэвтрүүлж, гол ба үндсэн авто зам, замын байгууламжийн сүлжээг өргөтгөн шинэчилж, олон түвшний уулзварыг байгуулан хүртээмжийг нэмэгдүүлж, авто замын түгжрэлийг бууруулна.

4.2.Шинэ суурьшлын бүс, дагуул хот, эдийн засгийн чөлөөт бүсийн бүтээн байгуулалтыг эрчимжүүлж, Улаанбаатар хотоос орон нутагт шилжин суурьшсан иргэд, аж ахуйн нэгжүүдийг цогц бодлогоор дэмжих замаар төвлөрлийг сааруулна.

4.3.Аймгийн төвүүдийг бие даасан хот болгон хөгжүүлж, орон нутаг төсвийн орлогоо бие даан бүрдүүлэх санхүү, эдийн засгийн боломжийг бүрдүүлнэ.

4.4.Эдийн засгийн бүсчилсэн хөгжлийн бодлогод тулгуурлан мал аж ахуй, газар тариалангийн үйлдвэрлэлийн тогтвортой өсөлтийг дэмжиж, хүнсний дотоодын хэрэгцээг ханган, экспортын хувь хэмжээг нэмэгдүүлнэ.

### **Тав.Ногоон хөгжлийн сэргэлт**

5.1.Уур амьсгалын өөрчлөлтийг сааруулахад дорвитой хувь нэмэр оруулах зорилгоор “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнийг үр дүнтэй өрнүүлж, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг дэмжих хууль, эрх зүйн орчныг бүрдүүлнэ.

5.2.Усны нөөцийг хамгаалж, хүн амыг баталгаат ундны усаар хангах, бэлчээрийг усжуулах, говийн бүс нутгийн усан хангамжийг

нэмэгдүүлэх, саарал усыг дахин ашиглах, хиймэл нуур, хөв цөөрөм байгуулж, ширгэсэн гол горхи, булаг, шандыг нөхөн сэргээнэ.

5.3.Байгальд ээлтэй дэвшилтэт технологи бүхий хог хаягдлыг дахин боловсруулах үйлдвэрүүдийг аймаг, нийслэлд бүсчлэн байгуулна.

5.4.Эдийн засаг, аж үйлдвэржилтийн сэргэлтийн бодлогыг хэрэгжүүлэхдээ байгаль хамгаалах үндэсний уламжлалт ёс заншлыг хадгалж, дэлхийн хөгжлийн чиг хандлагад нийцүүлэн ногоон хөгжлийн жишиг загварыг тодорхойлно.

### **Зургаа.Төрийн бүтээмжийн сэргэлт**

6.1.Төрөөс үзүүлэх үйлчилгээг цахимжуулж, төрийн хүнд суртлыг бууруулна.

6.2.Засгийн газрын бүтэц, зохион байгуулалтад цогц шинжилгээ хийж, үнэлэлт, дүгнэлт өгч, оновчтой бүтцийг тогтоон, төрийн зарим чиг үүргийг хувийн хэвшил, мэргэжлийн холбоодод шилжүүлнэ.

6.3.Төрийн хяналт, шалгалтын давхардсан тогтолцоог цэгцэлж, төлөвлөгөөт шалгалтыг түр хугацаанд зогсоон, төрийн байгууллагаас шаарддаг тусгай зөвшөөрөл, техникийн нөхцөлийн тоог бууруулна.

6.4.Төрийн өмчит аж ахуйн нэгжүүдийн үр ашиг, засаглалыг сайжруулж, олон нийтийн шууд хяналтад оруулах ажлыг зохион байгуулна.

6.5.Авлига, албан тушаалын гэмт хэрэгт оногдуулах ялын бодлогыг чангатгана.

6.6.Санхүүгийн хориг арга хэмжээ авах байгууллага /ФАТФ/-аас гаргадаг мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх стратегийн дутагдалтай улсын жагсаалт /саарал, хар жагсаалт/, Европын холбооны “Татварын зорилгоор хамтран ажилладаггүй бүс нутгуудын жагсаалт”-д орохгүй байх, түүнчлэн Монгол Улсын зээлжих зэрэглэлийг бууруулахаас сэргийлнэ.

--- оОо ---



**“ШИНЭ СЭРГЭЛТИЙН БОДЛОГО”-ЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ  
ЭХНИЙ ҮЕ ШАТНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨР**

Д/д	Үйл ажиллагаа	Хүрэх үр дүн
<b>Зорилт 1.1.Боомтуудын хатуу, зөөлөн дэд бүтцийг хөгжүүлэн ачаа болон зорчигч нэвтрүүлэх хүчин чадлыг дээшлүүлж, экспортыг нэмэгдүүлнэ.</b>		
1.1.1	Боомтуудыг хөгжүүлэх хөгжлийн ерөнхий төлөвлөгөө болон хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг тодотгох, шинээр нэмж боловсруулах замаар боомтуудын хөгжлийг хөрш орнуудын боомттой ижил түвшинд хүргэж, дэд бүтэц, тээвэр зохилон байгуулалтыг олон улсын стандартад нийцүүлэх	Бүх боомтын хөгжлийн төлөвлөгөө боловсруулагдсан байна.
1.1.2	Хилийн боомтоор бүх төрлийн бараа бүтээгдэхүүн нэвтрүүлэх асуудлыг хөрш орнуудтай дипломат шугамаар харилцан, шийдвэрлэх	Саналыг хөрш орнуудтай дипломат шугамаар хэлэлцэж шийдвэрлэсэн байна.
1.1.3	Боомтуудын ажиллах цагийг уртасгах чиглэлээр хөрш орнуудад дипломат шугамаар санал тавьж, шийдвэрлэх	Гэрээ, хэлэлцээр байгуулсан байна.
1.1.4	Экспортын бараанд ногдож байгаа тарифын болон тарифын бус саадыг бууруулах чиглэлээр гэрээ, хэлэлцээр хийж, хэрэгжүүлэх	Гэрээ, хэлэлцээр байгуулсан байна.
1.1.5	Боомтуудын үндсэн байгууламж /эрчим хүч, дулаан, усан хангамж, ариутгах татуурга, интернэтийн сүлжээ, гаалийн лаборатори, зорчигч болон ачаа тээврийн терминал-ийг өргөтгөн шинэчилж, зорчигч аялах, албан хаагчдын ажиллах ая тухтай орчныг бүрдүүлэх	Зорчигч болон ачаа нэвтрүүлэх хүчин чадал 3 дахин нэмэгдсэн байна.
1.1.6	Уул уурхайн бүтээгдэхүүний экспортын голлох боомтуудад чингэлэгт тээврийн терминал, ачиж буулгах терминал, шилжүүлэн ачиж терминалуудыг барих	Терминалуудыг барьж байгуулсан байна.
1.1.7	Боомтуудын ачаа нэвтрүүлэх хүчин чадлыг нэмэгдүүлэх нэмэлт байгууламж /дүүжин тээвэр, автомат удирдлагат тээвэр-уудыг судалж, барих	Боомтуудын ачаа нэвтрүүлэх хүчин чадал 2-3 дахин нэмэгдсэн байна.
1.1.8	Гаалийн хяналтын бусуудад ухаалаг гарц, орчин үеийн өндөр хүчин чадал бүхий рентген болон хяналтын тоног төхөөрөмж, лаборатори	Боомтуудад орчин үеийн өндөр хүчин чадал бүхий рентген, дээж авагч тоног төхөөрөмж, гаалийн



	Байгуулах	лаборатори суурилуулсан байна.
1.1.9	Гаалийн хяналт, бүрдүүлэлт, лабораторийн үйл ажиллагааг цахим хэлбэрт шилжүүлж, хилийн хяналт шалгалтад зарцуулах хугацааг бууруулах	Хилийн хяналт шалгалтад зарцуулах хугацаа 26-гаас доошгүй хувиар буурсан байна.
1.1.10	Уул уурхайн бүтээгдэхүүнийг тээвэрлэх, хилээр нэвтрүүлэх тээврийн зохион байгуулалтыг боомт тус бүрээр төлөвлөх	Уул уурхайн бүтээгдэхүүний экспортод зарцуулах хугацаа буурсан байна.
<p><b>Зорилт 1.2.Хилийн боомтуудыг төмөр зам болон хатуу хучилттай авто замаар үе шаттайгаар бүрэн холбон, тээвэр, логистикийн өрсөлдөх чадварыг дээшлүүлэн ачаа тээврийн урсгалыг сайжруулж, цаашид транзит улс болох суурь нөхцөлийг бүрдүүлнэ.</b></p>		
1.2.1	Боомт хүртэлх зам харилцааг сайжруулж, тээврийн хүчин чадлыг нэмэгдүүлэх	2650 км хатуу хучилттай авто зам, 4600 км төмөр зам барина. Шинээр 11 боомтыг авто замаар, 4 боомтыг төмөр замаар холбоно.
1.2.2	Үндэсний төмөр замын сүлжээг өргөтгөж, цаашид транзит улс болох суурь нөхцөлийг бүрдүүлнэ.	Баруун болон зүүн босоо тэнхлэгийн төмөр замын төслүүдийг эрчимжүүлнэ.
1.2.3	Ази-Европыг холбосон бүс нутгийн логистикийн төв байгуулж, дамжин өнгөрөх ачаа тээврийг нэмэгдүүлэх	Дамжин өнгөрөх ачаа тээврийн хэмжээ нэмэгдсэн байна.
<p><b>Зорилт 1.3.Монгол Улсын агаарын зайн зохион байгуулалт, агаарын замын ашиглалтыг сайжруулан дамжин өнгөрөх агаарын хөлгийн тоог нэмэгдүүлж, агаарын тээврийн либералчлалыг үе шаттайгаар үргэлжлүүлэх замаар ачаа тээврийн зангилаа төвийг бий болгож, аялал жуулчлалын салбарыг дэмжинэ.</b></p>		
1.3.1	Агаарын замын байнгын ажиллагаатай олон улсын боомтын тоог нэмэгдүүлж, карго тээвэр, аялал жуулчлалыг хөгжүүлэх	Орон нутгийн нисэх буудлын хүчин чадлыг сайжруулж, 6 нисэх буудлыг зорчигч, ачаа тээврийн харилцааны хилийн олон улсын боомт болгосон байна.
<p><b>Зорилт 1.4.Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалд тулгуурлан эдийн засгийн чөлөөт бүс, хуурай боомтуудыг үе шаттайгаар байгуулах замаар худалдааны эргэлтийг нэмэгдүүлнэ.</b></p>		
1.4.1	Хилийн зарим боомтыг нэмж чөлөөт бүс болгон хөгжүүлэх асуудлыг судалж, шийдвэрлүүлэх	Чөлөөт бүс шинээр нэмж байгуулсан байна.
1.4.2	Зарим боомтыг түшиглэн хип орчмын аялал жуулчлалыг хөгжүүлэх	Зургаан боомтыг аялал жуулчлалын боомт болгон хөгжүүлж, боомтын зэрэглэлийг нэмэгдүүлсэн байна.
1.4.3	"Хуурай боомтын тухай" Ази, номхон далайн эдийн засаг, нийгмийн комиссын гишүүн улсын Засгийн газрын хоорондын 2013 оны хэлэлцээрийн дагуу Алтанбулаг, Замын-Үүд, Сайншанд, Улаанбаатарт хуурай боомтуудыг үе шаттайгаар байгуулах	Олон улсын худалдаанд тээвэрлэж байгаа барааг ачиж буулгах, хадгалах, холбогдох хяналт шалгалт, үзлэг хийх нэг ба түүнээс дээш тээврийн горимоор далайн боомттой холбогдсон логистикийн төв байгуулсан байна.

**ХОЁР.ЭРЧИМ ХҮЧНИЙ СЭРГЭЛТ**

<p><b>Зорилт 2.1.Эрчим хүчний эх үүсвэр, дамжуулах, түгээх шугам сүлжээг шинээр барьж байгуулан хүчин чадлыг өргөтгөн нэмэгдүүлж, эрчим хүчний үйлдвэрлэл, хангамжийн найдвартай байдлыг дээшлүүлнэ.</b></p>	
2.1.1	<p>Тавантолгойн 450 МВт-ын хүчин чадалтай дулааны цахилгаан станц, 220 кВ-ын өндөр хүчдэлийн цахилгаан дамжуулах агаарын шугам барьж, өмнөд бүсийн стратегийн орд газрууд болон үйлдвэрлэл, технологийн паркуудын эрчим хүчний хэрэглээг хангах</p> <p>Жилд 3,150.0 сая кВт.ц цахилгаан эрчим хүч үйлдвэрлэх ба Оюутолгойн өсөн нэмэгдэх 2,242.5 сая кВт.ц хэрэглээ болон Тавантолгойн орд газрууд, бусад стратегийн ач холбогдол бүхий өмнөд бүсийн уул уурхайн төслүүдийн цахилгаан эрчим хүчний хэрэглээг дотоодоос хангасан байна.</p>
2.1.2	<p>Чойбалсангийн дулааны цахилгаан станцын хүчин чадлыг 50 МВт-аар өргөтгөж, зүүн бүсийн уул уурхай, аялал жуулчлалын төслүүдийн эрчим хүчний хэрэглээг хангах</p> <p>Зүүн бүсийн өсөн нэмэгдэж байгаа цахилгаан эрчим хүчний хэрэглээ ба Дорнод, Сүхбаатар аймгийн сум, суурин газар, уул уурхайн ордын баяжуулах, олборлох үйлдвэрүүд, аялал жуулчлалын цогцолборуудыг тасралтгүй, найдвартай эрчим хүчээр хангасан байна.</p>
2.1.3	<p>Амгалангийн дулааны станцыг өргөтгөн Улаанбаатар хотын зүүн бүсийн дулааны хэрэглээний өсөлтийг хангах</p> <p>Улаанбаатар хотын зүүн бүсэд Баянзүрх дүүрэг, Улиастай орчмын дахин төлөвлөлтийн хүрээнд бий болох орон сууцны шинэ хорооллуудыг дулаанаар хангасан байна.</p>
2.1.4	<p>Дулааны III цахилгаан станцын дэд бүтцийг түшиглэн 400 МВт-ын хүчин чадалтай шинэ эх үүсвэр барих</p> <p>Станцын хүчин чадал цахилгаанаар 400 МВт, дулаанаар 370 Гкал/ц-аар нэмэгдэж, Улаанбаатар хотын төвийн дүүргүүдэд өсөн нэмэгдэж байгаа дулаан, цахилгааны эрчим хүчний хэрэглээг хангасан байна.</p>
2.1.5	<p>Багахангайн 300 МВт-ын цахилгаан станцыг барьж, нийслэл Улаанбаатар хотод хийгдэх шинэ эко, ногоон бүтээн байгуулалтын төслүүдийн эрчим хүчний хэрэглээг хангах</p> <p>Жилд 1,855.9 сая кВт.ц цахилгаан эрчим хүч үйлдвэрлэж, төвийн эрчим хүчний нэгдсэн сүлжээнд нийлүүлэн, нийслэл Улаанбаатар хотод хэрэгжүүлэх цахилгаанаар ажиллах эко, ногоон төслүүдийг бүрэн хангах техникийн боломжийг бүрдүүлсэн байна.</p>
2.1.6	<p>Эрдэнэбүрэн-Мянгад-Улиастайн 220 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станц барьж Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станцын үйлдвэрлэх цахилгаан эрчим хүчийг бүс нутгийн сүлжээнд нийлүүлэх</p> <p>Баруун бүсийн эрчим хүчний систем, Алтай-Улиастай эрчим хүчний системийн үйлчлэх хүрээний баруун 5 аймгийн эрчим хүчний хангамж, хүртээмжтэй байдал дээшилсэн байна.</p>
2.1.7	<p>Төв аймгийн Хөшигийн хөндийд шинэ дагуул хотууд болон эдийн засгийн чөлөөт бүсийг байгуулж хөгжүүлэхэд шаардлагатай дулаан, цахилгаан хангамжийн эх үүсвэрийг шийдвэрлэх</p> <p>Шинэ дагуул хотын төлөвлөлтийн үе шатуудтай уялдуулан цахилгаан дулааны эх үүсвэрийг ашиглагдаж оруулсан байна.</p>

<b>Зорилт 2.2.Сэргээгдэх эрчим хүчийг зохистой харьцаагаар хөгжүүлэн усан болон хуримтлуурын станц барьж, эрчим хүчний нэгдсэн системийн найдвартай, тогтвортой байдлыг хангана.</b>	
2.2.1	Эрдэнэбүрэнгийн 90 МВт-ын усан цахилгаан станц барьж баруун бүсийн эрчим хүчний хэрэглээг бүрэн хангах
2.2.2	Төвийн эрчим хүчний нэгдсэн сүлжээнд 160 МВт.ц багтаамжтай цэнэг хуримтлуурыг ашиглан нэгдсэн сүлжээний оргил ачааллыг тохируулах боломжийг бүрдүүлэх
2.2.3	Эгийн голын усан цахилгаан станцын биологийн олон янз байдлын нөлөөллийн судалгааг дуусгаж, Дэлхийн өвийн хороонд хүргүүлэх
<b>Зорилт 2.3.Эрчим хүчний салбарыг санхүү, эдийн засгийн бие даасан тогтолцоонд үе шаттайгаар шилжүүлнэ.</b>	
2.3.1	Эрчим хүчний үнэ тарифыг индексжүүлж улирал тутам шинэчилнэ.
<b>Зорилт 2.4. Зүүн хойд Азийн эрчим хүчний нэгдсэн сүлжээнд эрчим хүч нийлүүлэх сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэр, сүлжээнд холбогдох хэт өндөр хүчдэлийн цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станцын бэлтгэл ажлыг хангана.</b>	
2.4.1	Өмнийн говьд барих сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрийн хүчин чадал, Зүүн хойд Азийн эрчим хүчний нэгдсэн сүлжээнд холбогдох улс хоорондын хил дамнасан хэт өндөр хүчдэлийн цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станцын техник, технологийн шийдэл, өмнийн говийн нар, салхины эх үүсгэврийг ашиглаж ногоон устөрөгч үйлдвэрлэх технологийн шийдлийг судалсан байна.
<b>Зорилт 2.5.Оросын Холбооны Улсаас Бүгд Найрамдах Хятад Ард Улс руу Монгол Улсын газар нутгаар дамжин өнгөрөх байгалийн хий дамжуулах хоолой барих бүтээн байгуулалтын ажлыг эрчимжүүлнэ.</b>	
2.5.1	Оросын Холбооны Улсаас Бүгд Найрамдах Хятад Ард Улс руу Монгол Улсын хийн хэрэглээний хэрэгцээг хий хуваарилах байгууламжуудын хүчин чадал, байршил, дамжуулах хоолойн техник, эдийн засгийн үндэслэлийг дуусгаж, барилга угсралтын ажлыг эхлүүлэх бэлтгэлийг хангах
<b>ГУРАВ.АЖ ҮЙЛДЭВЭРЖИЛТИЙН СЭРТЭЛТ</b>	
<b>Зорилт 3.1.Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл олголттой бүрэн цахимжуулж, өртөг зардлыг бууруулан хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлж, дэвшилтэт техник, технологид суурилсан, нэмүү өртөг шингэсэн уул уурхайн бүтээгдэхүүний хэмжээг дээшлүүлэн эрдэс баялгийн баталгаа нөөцийг арвижуулна.</b>	
3.1.1	Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл олголттой цахимжуулж, тусгай Ашигт малтмалын тусгай зөвшөөрлийг сонгон зөвшөөрлийн тоог нэмэгдүүлэн хөрөнгө оруулалтыг татах шалгаруулалт болон өргөдлөөр олгох үйл ажиллагааг



	боломжийг бүрдүүлэх	Цахимжуулж, хайгуулын ажилд зарцуулах хувийн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлж, эрдэс баялгийн нөөцийг арвижуулсан байна.
3.1.2	Улсын тусгай хамгаалалттай болон хилийн бүсэд орших хэтийн төлөв бүхий талбайд улсын төсвийн хөрөнгөөр геологи-хайгуулын ажил гүйцэтгэх	Эдийн засгийн хувьд өндөр ач холбогдолтой ашигт малтмалын /алт, зэс, өндөр технологийн түүхий эд гэх мэт/ эрэл, хайгуулын ажлыг төрийн өмчит компаниар гүйцэтгүүлж, эдийн засгийн эргэлтэд оруулсан байна.
3.1.3	Тавантолгойн нүүрс баяжуулах үйлдвэрийг ашиглалтад оруулж, ордыг иж бүрэн ашиглах нөхцөлийг бүрдүүлэх	Эхний модуль 10 сая тонн нүүрс баяжуулах үйлдвэрийг 2023 онд ашиглалтад оруулж, 928 ажлын байр шинээр бий болгож, экспортын орлогыг нэмэгдүүлсэн байна.
3.1.4	"Эрдэнэс-Тавантолгой" ХК-ийн ил уурхайн олборлолтын өртгийг бууруулах, хүчин чадлыг нэмэгдүүлэх зорилгоор технологийн харьцуулсан сонголт /1.олон утуурт экскаватор-конвейер, 2.цахилгаан экскаватор-конвейер, 3.цахилгаан экскаватор-хүнд даацын автосамосвал/ хийж, өөрөө олборлогч компани болох	Олборлолтын хүчин чадлыг үе шаттайгаар нэмэгдүүлж, төслийн хүчин чадлыг 50 сая тоннд хүргэсэн байна.
3.1.5	"Эрдэнэс-Тавантолгой" ХК-ийн ил уурхайн аргаар ашиглах боломжгүй нөөцийг дагд уурхайн аргаар ашиглаж, экспортын хэмжээг нэмэгдүүлэх	Олборлолтын хэмжээг 10 сая тонноор нэмэгдүүлж, 1500-1800 хүний ажлын байр шинээр бий болгосон байна.
<b>Зорилт 3.2.Нэмүү өртөг шингэсэн хүнд үйлдвэрлэлийг хөгжүүлж, дотоодын бүтээн байгуулалтын хэрэгцээг хангаж, экспортыг нэмэгдүүлнэ.</b>		
3.2.1	"Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ын үр ашгийг нэмэгдүүлэх зорилгоор уул уурхай-металлурги химийн нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн цогцлобор /зэсийн баяжмал боловсруулах үйлдвэр, исэлдсэн хүдрээс катодын зэс үйлдвэрлэл/-ыг байгуулах	Паркийн хүрээнд баригдах үйлдвэрүүд ашиглалтад орж жигд 135 мянган тонн катодын цэвэр зэс үйлдвэрлэснээр экспортын орлого нэмэгдэж, 1050 ажлын байр шинээр бий болгосон байна. Зэсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх дагалдах жижиг, дунд үйлдвэрүүдийн кластер байгуулсан байна.
3.2.2	Хар төмөрлөгийн үйлдвэрлэлийг дагалдах үйлдвэрүүдийн хамт хөгжүүлж ган бүтээгдэхүүний дотоодын хэрэгцээг хангах	Төмрийн хүдрийг дотооддоо боловсруулж, нэмүү өртөг шингэсэн зэсийн бүтээгдэхүүн болох 350 мянган тонн ган бүтээгдэхүүн үйлдвэрлэх "Монгол ган цогцлобор I", 500 мянган тонн ширэм, 1 сая тонн кокс үйлдвэрлэх Алтанширээт аж үйлдвэрийн парк, 200 мянган тонн ган бүтээгдэхүүн үйлдвэрлэх Эрдэнэтийн төмөрлөгийн үйлдвэр төслүүд хэрэгжиж дууссанаар 2025 он гэхэд дотоодын гол нэрийн ган бүтээгдэхүүний /арматур гэх мэт/ хэрэгцээний 80 хувийг хангаж, экспортод гаргах бүтээгдэхүүний тоо хэмжээ нэмэгдсэн байна.



3.2.3	Оюулгойн ордыг түшиглэн зөсийн баямал боловсруулах үйлдвэр байгуулж катодын зэс, алт, мөнгө зэрэг нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх	Төслийн хүрээнд баригдах үйлдвэрүүд ашиглалтад орж жилд дунджаар 257 мянган тонн катодын цэвэр зэс, 5.7 тонн алт, 57 тонн мөнгө үйлдвэрлэснээр экспортын орлого нэмэгдсэн байна.
<b>Зорилт 3.3. Газрын тосны баталгаат нөөцийг өсгөж, олборлолтыг нэмэгдүүлэх замаар дотоодын газрын тос боловсруулах үйлдвэрийг түүхий эдээр хангана.</b>		
3.3.1	Газрын тосны бүтээгдэхүүний импортын хараат байдлыг бууруулж, дотоодын түүхий эдэд тулгуурласан газрын тос боловсруулах үйлдвэрийг барьж байгуулан нефть-химийн аж үйлдвэрийн суурийг тавих	Үйлдвэр ашиглалтад орж бүрэн хүчин чадлаар ажилласнаар түлш, шатахууны импортын хамаарлыг бууруулж, нефть-химийн аж үйлдвэрийн шинэ салбар бий болж, улсын төсөвт хувь нэмэг оруулахын зэрэгцээ түлш, шатахууны дотоодын хэрэгцээний 50-60 хувийг хангаснаар гадаад худалдааны алдагдал 1 тэрбум орчим ам.доллараар буурсан байна.
